# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
# ТОГТООЛ

2017 оны 07 сарын 17 өдөр Дугаар 35 Мандалговь

## Хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль" –ийн 77 дугаар зүйлийн 77.3 дах заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам "-ын 4 дүгээр зүйлийг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1.Хот тохижуулах газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2,143,687,850 /хоёр тэр бум нэг зуун дөчин гурван сая зургаан зуун долоон мянга найман зуун тавин/ төгрөгийн балансын үнэ бүхий Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгыг Биеийн тамир спортын газарт шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг Биеийн тамир спортын газрын дарга М.Наранбадрах, данс бүртгэлээс хасахыг Хот тохижуулах газрын дарга Д.Мөнхцоожид тус тус даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР

0100085

В